



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Бага тойруу 54, Арслантай гүүр, Багшийн хөгжлийн ордон

Утас: 70140069 Факс: 70140065
Цахим шуудан: letter@agency.edu.mn
Цахим хуудас: <http://edu.gov.mn>

2024.05.02 № 01/1805

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тодруулга авах болон хүсэлт гаргах тухай танай албан бичигтэй танилцлаа.


Бид тендерийн баримт бичиг боловсруулахдаа өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажилладаг.

Тиймээс дараахь тайлбарыг хүргүүлж байна.

Нэг. ТШЗ 19.1 "21 аймагт сурах бичгийг нэгэн зэрэг тээвэрлэх 5 тн-оос дээш даацтай ачааны машин нь өөрийн эзэмшлийн 5 ба түүнээс дээш, бусад машиныг хөлсөөр ажиллуулж болох бөгөөд хөлсөөр ажиллуулах тохиолдолд гэрээг хавсаргана" гэдэгт: Тээвэр хийдэг туршлагатай байгууллага гэснийг батлах зорилготой.

Хоёр. ТШЗ 19.2 "Сүүлийн гурван жил (2021, 2022, 2023)-ийн аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй үнийн дүн бүхий ижил төстэй бараа, үйлчилгээ нийлүүлсэн туршлагатай байх" гэдэгт: Төсөвт өртгийн 40 хувь гэдгээ тодотгож оруулснаас бус сүүлийн 3 жил хийсэн тээврийн ажил нь тасралтгүй байх эсэх нь бидэнд чухал бус бөгөөд нөгөөтэйгүүр өрсөлдөх тэгш боломжийг хангаж байгаа юм.

Гурав. "Ижил төстэй ажил гэдэгт аймаг, сум, дүүрэгт барааг тээвэрлэн хүргэж байсан туршлагыг баримтаар нотолж ирүүлэх" гэдэгт: Аймаг, сум, дүүрэгт "ямар нэгэн бараа"-г хүргэж байсан туршлагатай байх гэж ойлгож болно. Энэ нь нэгж тус бүрт бараа хүргэж байсан туршлагыг харах зорилготой юм.



Боловсролын ерөнхий газар
Удирдлага
Дарга
Төмөр-Очир Ням-Очир
2024-05-02 09:49:06